



## МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: **Ухнаагийн Хүрэлсүх**

Засгийн газрын тэргүүн: **Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ**

**Тайван замаар эсэргүүцэгч нарт оногдуулсан эрүүгийн ялыг хэвээр үлдээв. Эрх баригчид ЛГБТИ хүмүүсийн тайван хуран цуглах эрхийг хязгаарласан. Дур зоргоор цагдан хорих явдал түгээмэл бөгөөд дарамталж хэрэг хүлээлгэх нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Эрх баригчид уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны доройтлоос малчдыг хамгаалж чадсангүй.**

### Үзэл бодлоо илэрхийлэх, хуран цуглах эрх чөлөө

Нэгдүгээр сард давж заалдах шатны шүүх “Дайны эсрэг” (“No war”), “Давхар стандартын эсрэг” (“No double standard”) хөдөлгөөний таван идэвхтэнд оногдуулсан ялыг хэвээр үлдээв. Тэдэнд 2021 оны аравдугаар сард өрнөсөн тайван жагсаалын үеэр хууль сахиулагчийг эсэргүүцсэн гэх хэргээр 2022 оны арваннэгдүгээр сард 12 сарын хугацаанд оршин суугаа дүүргээсээ явахыг нь хориглож зорчих эрхийг нь хязгаарласан ял оногдуулсан. Дөрөвдүгээр сард Дээд шүүхээс эдгээр таван хүний хяналтын шатны журмаар гаргасан гомдлыг хэлэлцэхээс татгалзжээ.

“Үндэсний эв нэгдэл”, “төрийн нууц”-ыг хамгаалах үндэслэлээр олон нийтийн сүлжээний контентийг хянах, устгах болон хаягийг түдгэлзүүлэх, устгах эрх мэдлийг Засгийн Газарт олгосон “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай” хуулийг олон нийт хүчтэй эсэргүүцсэний дараа нэгдүгээр сарын 27-нд Ерөнхийлөгч хориг тавьсан. УИХ уг хуулийг нэгдүгээр сарын 20-нд олон нийтээр хэлэлцүүлэлгүй баталсан юм.<sup>1</sup>

Наймдугаар сард Тэгш эрх, бахархлын өдрүүдээр ЛГБТИ хүмүүсийн эрхийн төлөөх жагсаал зохион байгуулахаар мэдэгдсэн ч эрх баригчид бүртгэхээс татгалзсан талаар ЛГБТ төв мэдээлсэн.

### Дур зоргоор цагдан хорих, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах

НҮБ-ын дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх Ажлын хэсгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх баталгаа алдагдсан, ялангуяа ТЕГ, АТГ зэрэг тусгай чиг үүрэгтэй байгууллагууд шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах явдал өндөр хувьтай байгаа, түүнчлэн дарамт шахалт үзүүлэн хэрэг хүлээлгэх явдалд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн. Өмгөөлөгчид үйлчлүүлэгчийнхээ хавтаст хэрэгтэй цаг тухайд нь, бүрэн танилцах боломжгүй байгаа нь шүүхээс өмнө цагдан хорих шийдвэрийн эсрэг үр дүнтэй мэтгэлцэхэд нь нөлөөлж байгаа зэрэг санаа зовних бусад асуудал байна.

### Эрүүл орчинд амьдрах эрх

Говийн бүс дэх нүүрс болон бусад уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчинд хор хөнөөл учруулж, малчдын эрүүл мэнд, амьжиргаанд сөргөөр нөлөөлсөөр байна. Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн нөлөөллийн талаар Форум-Ази ТББ-аас гаргасан шинэ тайланд дурдсанаар тоос шороо, дуу чимээний бохирдол, аюултай хог хаягдлыг зөв зохицуулаагүй нь нүүдэлчин малчдын дунд харшил, халдварт өвчин, амьсгалын замын болон сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал үүсгэхийн зэрэгцээ бэлчээр хомсдож, малын эрүүл мэнд доройтож байгааг онцолжээ.

### Цэвэр усаар хангагдах эрх

Тавдугаар сард Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба нийслэл Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн оршин суугчдаас гаргасан ундны усны чанар муугаас эрүүл мэндээрээ хохирч, тууралт гарч, ходоод, гэдэс өвчилсөн зэрэг олон зуун гомдол, мэдээллийг шалгасны эцэст тус албанаас ус дамжуулах шугам хоолой тавьсан аж ахуйн нэгж, албан тушаалтнууд хариуцлага хүлээхийг мэдэгджээ.

<sup>1</sup> “Монгол Улсын төр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна” 7 дугаар сарын 17. Монгол хэлээр.

Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа улс төрийн үзэл баримтлал, шашин, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байж, гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнл

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж, #АВ төвийн 7 давхар 701 тоот

Утас/Факс: 976-7000-4705

members@amnesty.mn

www.amnesty.mn